



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАР**

**БУЛГАН АЙМГИЙН ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН  
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН 2017 ОНЫ ХҮҮХЭД ХАРАХ ҮЙЛЧИЛГЭЭ,  
ЖАРГАЛАНТ ЗУСЛАНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН.**

## **АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

**2018 ОН**

## АГУУЛГА

Аудитын нэр.....	3
Аудитын код.....	3
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх.....	3
Аудитын зорилт.....	3
Аудитад хамрах хүрээ.....	4
Аудитын арга зүй.....	4
Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд.....	4
Аудитын хийх бүрэлдэхүүн, хугацаа.....	4
Аудитын эрсдлийн үнэлгээ.....	4
Аудитын тайлан.....	5
Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц.....	5

Хавсралт 1. Эрсдэлийн үнэлгээ

Хавсралт 2. Асуудлын шинжилгээ

Хавсралт 3. Арга зүй

Хавсралт 4. Аудитын хөтөлбөр

Хавсралт 5. Аудитын үр өгөөжийн төлөвлөлт

Хавсралт 6. Аудитын зардлын тооцоо

БАТЛАВ.

АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

## ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2018.04.27

Булган

### 1. Аудитын нэр:

Булган аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Хүүхэд харах үйлчилгээ, Жаргалант зуслангийн санхүүгийн үйл ажиллгааны үр дүн.

### 2. Аудитын код:

БУА-2018-01-ГА

### 3. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Монгол улсын ерөнхий аудиторын тушаал, аймгийн Төрийн аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу бүрэн эрхийн хүрээнд аудит хийнэ.

### 4. Аудитын зорилт:

Аудитын зорилт нь Булган аймгийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Хүүхэд харах үйлчилгээ, Жаргалант зуслангийн 2017 оны санхүүгийн үйл ажиллагаа, үр дүнд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж өгч, холбогдох байгууллага албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ.

Аудитыг дараах үндсэн зорилтын хүрээнд хийж гүйцэтгэнэ.

Үүнд:

- Хүүхэд харах үйлчилгээнд баримтлах зарчим, тавигдах шаардлага, зохион байгуулалт, санхүүжилтыг хэрхэн бүрдүүлсэн, үр ашигтай зарцуулсан эсэх.
- Хүүхдийн Жаргалант зуслангийн бүтэц зохион байгуулалт, санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, үр ашиг
- Төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт, тавих дотоодын хяналтыг хэрхэн үр ашигтайгаар хэрэгжүүлж ямар үр нөлөөтэй ажилласан эсэх.
- Өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлттэй, үр ашигтайгаар зарцуулсан эсэх.
- Дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байдал
- Хууль тогтоомжийг баримталсан эсэх

**5.Аудитын хамрах хүрээ:**

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Хүүхэд харах үйлчилгээ, Жаргалант зуслангийн 2017 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан мэдээ, холбогдох судалгаа баримтууд хамрагдана.

**6.Аудитын арга зүй:**

Аудитын явцад аудитын олон улсын стандарт, төрийн хяналт шалгалтын стандартыг мөрдөж, санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан, холбогдох асуудлаар аудитад хамрагдсан төсөвт байгууллагын ажилтнуудаас асуулга авах, судалгаанд дүн шинжилгээ хийх зэрэг аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулна.

**7.Шалгуур үзүүлэлт:**

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Хүүхэд хамгааллын тухай хууль
- Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Ариун цэврийн тухай хууль
- Хүнсний тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Засгийн газрын холбогдох тогтоол шийдвэрүүд, хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан дүрэм журам
- Холбогдох бусад хууль, тогтоомж

**8. Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа:**

Аудитыг Төрийн аудитын газрын удирдамжаар гүйцэтгэж, Тэргүүлэх аудитор Б.Анхбаяр удирдан, гүйцэтгэлийн хяналтыг Аудитын менежер Ж.Энхцоодол, явцын хяналтыг ахлах аудитор Г.Ганбаатар тавьж, гэрээт ажилтан Х.Баттулга 2018 оны 5 дугаар сарын 15-наас эхлэн 2018 оны 6 дугаар 20-ны дотор удирдамжийн дагуу явуулна.

**9. Эрсдэлийн үнэлгээ:**

Аудитын төлөвлөлтийн үе шатны явцад судалсан баримт материал урьдчилсан дүн шинжилгээ харилцан ярилцлагад үндэслэн Хүүхэд харах үйлчилгээний хэрэгжилт үр дүнд хийх ерөнхий эрсдэлийг “ДУНД” гэж үнэлсэн. (Дэлгэрэнгүйг Хавсралт №1-д үзүүлэв)

**10. Аудитын тайлан:**

Аудитын тайлан нь энгийн, тодорхой, уялдаа холбоотой байх бөгөөд ерөнхий зүйл, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, байгууллагын дарга, холбогдох албан тушаалтан нарын санал болон хавсралт судалгаа тооцоо, тайлбаруудаас бүрдэнэ.

Аудитын тайлангийн төслийг шалгагдагч байгууллагын удирдлагад танилцуулж, санал авч аудитын удирдагчид танилцуулан баталгаажуулна.

**11. Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц.**

- Боловсон хүчин: Нийт 1 хүн 27 өдөр хүн/өдөр
- Санхүүгийн нөөц: 798,806 төгрөг
- Техник хэрэгсэл: Комьпютер, принтер, бусад хэрэгслэл.

ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛСАН:

ГЭРЭЭТ АЖИЛТАН

Х.БАТТУЛГА

ХЯНАСАН:

МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ